

БАЯНХОНГОР АЙМГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025 оны 02 дугаар сарын 25

Номгон

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн үр дүнг орон нутгийн удирдлагууд, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангаж, www.new.unelgee.gov.mn цахим санд байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.

Аймгийн 2024 онд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2 бүлэг болгон танилцуулъя.

Нэгдүгээр бүлэг: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тайлагнасан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

Баянхонгор аймгийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын monitoring.ags.gov.mn имэйл хаягаар дүгнэлт, илтгэх хуудсыг тайлан тус бүртэй хүргүүлсэн тул энэхүү тайланд тоймлон дурдъя.

Нэг. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тойм:

Монгол Улсын Хууль, Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын Хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэн тогтоол шийдвэрийг орон нутагт үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор 2024 онд 14 удаагийн тайланг <http://new.unelgee.gov.mn> цахим системээр тайлагнасан байна.

Д/д	Тайлангийн нэр	Шийдвэрийн	Заалтын	Өөрийн	Дээд шатны
-----	----------------	------------	---------	--------	------------

		тоо	тоо	үнэлгээ	байгууллагын үнэлгээ
1	2	3	4	10	11
1	2023 оны жилийн эцэс	107	196	91.11%	81.02%
2	2024 оны II сар	65	98	84.40%	
3	Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай	2	4	0%	
4	2024 оны III сар	76	114	85.09%	
5	2024 оны УИХ-ын болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт	2	2	85.00%	
6	2024 оны IV сар	80	119	86.84%	
7	2024 оны V сар	80	114	86.42%	
8	2024 оны эхний хагас жил	126	206	82.99%	73.09%
9	2024 оны VII сар	85	120	85.40%	
10	2024 оны VIII сар	88	128	87.33%	
11	2024 оны IX сар	93	136	85.97%	
12	2024 оны X сар	94	137	89.62%	
13	2024 оны XI сар	95	138	91.16%	
14	2024 оны жилийн эцэс	148	252	96.13%	81.06%
	Дүн	1141	1764		

Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайлагнасан тайланд хагас, бүтэн жилээр үнэлгээ хийж байгаа бөгөөд сарын тайланд үнэлгээ хийдэггүй нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд 2024 оны жилийн эцсийн байдлаар 148 хууль тогтоомжийн 252 заалтын хэрэгжилтийг 96.13 хувийн хэрэгжилттэй тайлагнажээ.





Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайланг 2024 онд 14 удаа тайлагнасан нь давтамжийн хувьд 2023 онтой ижил түвшинд байгаа бол хяналтад авч тайлагнасан шийдвэр 1141 болж 2.3 дахин, заалтын тоо 1764 болж 1.9 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь нэг талаас орон нутагт хамааралтай хууль, тогтоомжийг бүрэн хяналтад авсан сайн талтай хэдий ч нөгөө талаас хүчингүй болсон, дуусгавар болсон, бүрэн хэрэгжсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтаас хасаагүй, сар бүр үнэлдэггүй нь бүх шатанд хэт ачаалал үүсгэсэн, үр дүнгүй ажил байлаа.

Хоёр. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2024 оны 2, 3, 4, 5 дугаар сар, эхний хагас жилийн байдлаар 5 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын цахим системээр хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилтийн товчоог өмнөх оны дүнтэй харьцуулан хүснэгтэд үзүүлье.

Д/д	Тайлагнасан хугацаа	Хэрэгжилтийн хувь	Хяналтад авсан арга хэмжээний тоо	100 хувь	90 хувь	70 хувь	50 хувь	30 хувь	0 хувь	Хугацаа болоогүй/ үнэлэх боломжгүй
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	2021 оны жилийн эцэс	81.18%	17	5	4	7	-	1	-	-
2	2022 оны жилийн эцэс	66.67%	18	2	2	7	6	1	-	-
3	2023 оны жилийн эцэс	94.71%	18	14	-	3	-	-	-	1
4	2024 эхний оны хагас жил	89.41%	18	11	-	6	-	-	-	1

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтээс 5.3 хувиар буурсан нь хэрэгжилтийг өссөн дүнгээр тайлагнаагүй байсантай холбоотой байна.

Гурав.Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/6 дугаар тогтоолоор “Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг 8 бүлэг, 8 зорилго, 24 зорилт, 105 ажил арга хэмжээтэй батлан хэрэгжүүлж ажилласан ба 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтийн дундаж 95.71 хувь болж, өмнөх оноос 1.41 хувиар нэмэгдсэн байна. Дэлгэрэнгүйг зургаар үзүүлвэл:




Дөрөв.Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2024 оны жилийн эцсийн байдлаар 91.14 хувьтай хэрэгжсэн байна.



Тав.Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан аргачлалаар боловсруулж аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17/59 дүгээр тогтоолоор салбарын 24, төсвийн ерөнхийлөн захирагчийн 38, хөтөлбөрийн 51 үр дүнгийн хүрээнд 250 үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг батлан 87.2 хувьтай хэрэгжүүлсэн байна.



Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд:

1.Салбарын 24 үр дүн тодорхойлсноос 45.8 хувь нь буюу 11 үр дүн "Тодорхой үр дүнд хүрсэн", дундаж хэрэгжилт 68 хувьтай байна.

2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн 38 үр дүнг төлөвлөн хэрэгжүүлсний 86.8 хувь нь буюу 33 үр дүн "Тодорхой үр дүнд хүрсэн" бөгөөд дундаж хэрэгжилт 87.2 хувьтай байна.

3.Хөтөлбөрийн 51 үр дүнгээс 84 хувь нь буюу 43 үр дүн "Тодорхой үр дүнд хүрсэн" ба дундаж хэрэгжилт 84 хувьтай байна.

4.Дээрх 3 түвшний үр дүнг хэрэгжүүлэх зорилгоор дэвшүүлсэн 250 үндсэн үйл ажиллагаа, төсөл арга хэмжээний 76.8 хувь нь “Тодорхой үр дүнд хүрсэн” бөгөөд дундаж хэрэгжилт 80 хувьтай үнэлэгдсэн байна.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний эцсийн үр дүн болох “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн үнэлгээгээр Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу “87.2 хувь”-ийн гүйцэтгэлтэй байна гэж дүгнэсэн.

Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг үр дүнд суурилсан төлөвлөлтийн аргачлалаар боловсруулсан нь хөндлөнгийн хяналт хийхэд ойлгомжтой, хялбар байсан. Цаашид анхаарвал зохих дараах алдаа, дутагдал илэрлээ. Үүнд:

1.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, тогтоомж, Төсвийн тухай хуулийн цаглаврын зөрүүтэй байдлаас шалтгаалан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, 18.6 дугаар зүйлийг хэрэгжүүлэн “Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г батлуулдаггүй.

2.Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг үр дүнд суурилсан төлөвлөлтийн аргачлалаар 4 түвшний үр дүнг тодорхойлж, түүнд хүрэх төсөл, арга хэмжээ, үйл ажиллагаа тус бүрийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлон боловсруулах шийдвэр Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан хэдий ч үр дүнгийн түвшний ангилал, шалгуур үзүүлэлтийн сан зэрэг арга зүйн заавар хангалтгүй байдлаас шалтгаалан түвшин хоорондын үр дүн, үйл ажиллагааны уялдаа хангагдаагүй, зарим шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг буруу тодорхойлогдсон.

3.Үр дүнд суурилсан бодлогын баримт бичгийн гүйцэтгэлийг тайлагнах, үнэлэх аргачлал, журам батлагдаагүй нь төрийн байгууллага, албан хаагчдын тайлан, гүйцэтгэл зөрүүтэй байхад нөлөөлж, эцсийн дүнг нэгтгэн тооцоход хүндрэл учруулж байна.

4.Бодлогын баримт бичгийг боловсруулахад нөхцөл байдлын дүн шинжилгээг бодитой хийгээгүй, бодлогын хувилбарыг оновчтой боловсруулаагүйгээс хэрэгжих боломжгүй, үр дүнгүй “Үр дүн”, “Үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ”-г цөөнгүй тодорхойлсон байна.

Зургаа. Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тойм:

Аймгийн хэмжээнд 2024 онд “Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь”, “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур


амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох”, “Эх хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөр”, “Сэргийлж болох эх нярайн эндэгдлийг бууруулах нь”, “Хамтарсан багийн гишүүдийн айл өрхөд үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх, тараах 6-10 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан мэдээллийн багц боловсруулах”, “Хамгаалах байр тохижуулах”, “Монгол унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь /Ensure/”, “Бага насны хүүхдийн цогц хөгжилд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх нь” зэрэг 8 төсөл, хөтөлбөр хэрэгжсэн байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Төсөл хөтөлбөр	Зарцуулсан хөрөнгө эх үүсвэр	Хэрэгжиж буй сумдын тоо	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5
1	“Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь	Хүүхдийг ивээх сан Японы гадаад хэргийн яам 80,000,000 орчим	1	100%
2	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох	МУ-ын ЗГ, ХБНГУ-ыг ЗГ-ын хооронд байгуулсан хамтын ажиллагааны дагуу Германы сэргээн босголт зээлийн банк (KfW)-ын хөрөнгө оруулалт 1.099.510.858	3	100%
3	“Эх хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөр”	НҮБ-ын Хүүхдийн сан 86.017.100	20	97,5%
4	Монгол унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь		4	90,5%
5	“Сэргийлж болох эх нярайн эндэгдлийг бууруулах нь	НҮБ-ын Хүүхдийн сан 11.594.000	2	100%
6	“Хамтарсан багийн гишүүдийн айл өрхөд үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх, тараах 6-10 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан мэдээллийн багц боловсруулах”,	НҮБ-ын Хүүхдийн сан 16.100.000	20	100%
7	“Хамгаалах байр тохижуулах”,	НҮБ-ын Хүүхдийн сан 3.000.000	1	100%
8	Бага насны хүүхдийн цогц хөгжилд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх нь	НҮБ-ын Хүүхдийн сан	1	100%

Тайлант онд хэрэгжсэн төслүүдийн хэрэгжилтийн дундаж 97.6 хувьтай байна.

Долоо.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тойм:

Засгийн газрын 19 гишүүнтэй Баянхонгор аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний 1626 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Монгол Улсын Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтэд хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажилласнаар гэрээний хэрэгжилт, үр дүн сайжирсан байна.



Найм.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлт тогтоох, тайлан гаргах журам”, “Аргачлал, загвар батлах тухай” Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу 20 зорилтын хүрээнд 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, баталсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 95 арга хэмжээний биелэлтийн дундаж 96.2 хувьтай байна. Дэлгэрэнгүйг доорх зурагт үзүүлэв.



Ес.Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Баянхонгор аймаг нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлж төрийн байгууллагын ил тод, нээлттэй байхаар заасан 5 бүлэг, 46 төрлийн мэдээллийг 98 үзүүлэлтээр аймгийн албан ёсны www.bayanhongor.gov.mn болон 20 сумын албан ёсны цахим хуудсанд байршуулан хөгжүүлж ажиллаж байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийн тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний new.unelgee.gov.mn цахим системд байршуулан, хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 44 үзүүлэлт бүрэн хэрэгжсэн, 2 үзүүлэлт хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй үнэлэгдсэн.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын 4.1-д заасны дагуу “Аймгийн хэмжээний нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн тайлан”, сум, аймгийн Засаг даргын харьяа агентлаг, улсын төсөвт болон орон нутгийн өмчийн байгууллагуудын “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ”-г хийж Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах орон тооны бус зөвлөлд 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1а/67 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээг байгууллагын албан ёсны цахим хуудас, шилэн индекс (shilen.gov.mn), аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан (<https://bayankhongor.igovernment.mn/>)-гаар ирүүлсэн тайлан болон шилэн дансны (shilendans.gov.mn) цахим хуудаст байршуулсан мэдээлэлд үндэслэн үнэлгээг хийхэд дараах хүндрэлтэй асуудал гарч байна. Үүнд:

1.Босоо удирдлагатай байгууллагын хувьд бие даасан албан ёсны цахим хуудас байхгүй, дээд шатны байгууллагын цахим хуудсанд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын мэдээллийг байршуулдаггүй, Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагууд албан ёсны цахим хуудас хийлгэхэд санхүүгийн хувьд бэрхшээлтэй, 12 байгууллага албан ёсны цахим хуудасгүй байна. Мөн Боловсролын газар цахим хуудас хийлгэсэн боловч Үндэсний дата төв дээр код давхардсан шалтгаанаар ашиглах боломжгүй нөхцөлтэй байна.

2.Сумдад албан ёсны цахим хуудсыг хариуцан нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангах боловсон хүчин дутагдалтай.

3.Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тайланг хүлээж авах, үнэлэх 2 сувагтай. Үнэлгээг Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу үнэлж байгаа хэдий ч дараах шалтгаанаар 2 системийн үнэлгээ зөрдөг. Үүнд:

3.1.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын ил тод байдлын тайланг Засгийн газрын new.unelgee.gov.mn, сум,

байгууллагуудын тайланг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний bayankhongor.igovernment.mn цахим сангаар хүлээн авч, тус журмын “6.7... байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ тооцдог аргачлалыг баримтлан 100 хувь (90-100 хүртэл хувь); 70 хувь (50-89 хүртэл хувь); 30 хувь (10-49 хүртэл хувь); 0 хувь (0-9 хүртэл хувь); “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” хэмээн үнэлдэг.

3.2.Шилэн индексийн shilen.gov.mn цахим системээр тайлагнадаг. Тайлангийн үнэлгээг хийхэд shilen.gov.mn систем дээр тухайн шалгуур үзүүлэлтийн тайланг өөр холбоосоор илгээсэн байсан ч 352 дугаар тогтоолоор батлагдсан 4 шалгуур үзүүлэлтийн дагуу 10 ба түүнээс дээш оноо тавигддаг, өөрөөр хэлбэл шаардлага хангаагүй үзүүлэлт оноо авах боломжтой хийгдсэн.

4.Засгийн газрын 352 дугаар тогтоолоор мэдээллийн хүртээмжтэй байдлыг цахим хуудас 15, мэдээллийн самбар 10, бусад суваг 5 гэсэн заалтыг бодит байдал дээр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Өөрөөр хэлбэл хуулийн 5 бүлгийн 46 үзүүлэлтийг 98 заалтыг мэдээллийн самбарт байршуулах нь ач холбогдолгүй, самбарын зай талбайн хувьд багтахгүй нөхцөл байдал үүсч байна. Шилэн дансанд байршуулсан мэдээллийг албан ёсны /суваг/ цахим хуудсанд байршуулсан гэж үзэх эсэх, зөвхөн байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулахыг цахим хуудсанд байршуулснаар тооцох эсэх нэгдсэн чиглэл байхгүй.

5.Төрийн байгууллагын хувьд ил тод байдлын шалгуурын 5.8 дахь “Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл” нийтлэг байдлаар хамааралгүй. Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээс шалтгаалан ил тод байдлын шалгуурын 1-27 хүртэл үзүүлэлт тухайн байгууллагын чиг үүрэгт хамааралгүй байна.

Арав. Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Аймгийн хүний нөөцийн хөгжлийн бодлого нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн стратеги төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон хүний нөөцийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх нэгдсэн хөтөлбөр болон нутгийн захиргааны байгууллагуудын бусад хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны

хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Арван нэг. Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийг биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд сум, агентлагуудын үйл ажиллагааны тайлан, шалгуур үзүүлэлтийн дагуу тоон мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг 4 чиглэлд "Сумдын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай" удирдамжийн дагуу сумдад ажиллан "Тэрбум мод", "Хог хаягдлын менежментийг сайжруулах" "Цахим засаглал"-ын чиглэлээр хийсэн ажлын тайланг бодит байдал дээр нь тулган баталгаажуулж үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.

"Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж, зөвлөмж боловсруулах ажлын хэсгийг мэргэжлийн хүмүүсийг оролцуулан аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/78 дугаар захирамжаар байгуулан "Тэрбум мод" "Хог хаягдал", "Цахим шилжилт", зэрэг тэргүүлэх чиглэлийн тайланг үнэлж, дүгнэлээ.

11.1.Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой "Тэрбум мод" төсөл, арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийг Шинээр тарьсан мод "Тодорхой үр дүнд хүрсэн" буюу 70 хувь, Ургалтын хувь "Үр дүнтэй" буюу 100 хувь, Хот суурины эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь "Үр дүнтэй" буюу 100 хувь, нийт дундаж үнэлгээ "90 хувь" буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэв. Тэрбум мод тэргүүлэх чиглэлийн хүрээнд Баянхонгор аймагт дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээнд тусгагдсан Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Баянхонгор аймаг 2023 онд гурван мод үржүүлгийн газрыг шинээр байгуулсан нь нутгийн хөрсөнд зохицсон тарьц суулгацыг нийлүүлэх боломжийг бүрдүүлж байсан бол тайлант онд нэг ойн зурвас газрыг шинээр бий болгосон байна.

2.Баянхонгор аймгийн хэмжээнд 5783 иргэн, 533 айл өрх, 283 аж ахуйн нэгж байгууллага мод тарих үйл ажиллагаанд оролцон 10 гаруй төрлийн 147.148 ширхэг мод тарьж 84.2 га талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүллээ. Нийт тарьсан модны амьдралтын хувь 77 хувь байна. Үүнээс:

- Хамгаалалтын зурваст 14 сумын нутаг дэвсгэрийн 18 байршилд 35.8 га талбайд 50608 ширхэг мод,

- Аж ахуйн нэгж, байгууллагын орчин тойрон болон цэцэрлэг, саадны 3.7 га талбайд 25226 ширхэг мод,

- Ойжуулалт 24.4 га талбайл 36420 ширхэг мод,

- Гол, татмын ойжуулалтад 4.8 га талбайд 8600 ширхэг мод,

- Баг, хороонд шинээр байгуулсан бичил цэцэрлэгт хүрээлэн 10 сумын нутаг дэвсгэрт 15,4 га талбайд 21377 ширхэг мод тарьж, нөхөн тарилтаар 8600 ширхэг мод тарьсан байна.

3.Орон нутагт дасан зохицсон тарьц суулгацыг тарьж ургуулах зорилгоор тайлант онд 8 аж ахуйн нэгж, байгууллага 5 төрлийн 121 кг үрийн нөөц бүрдүүлж, үрээр 20060 ширхэг мод, мөчрөөр 8 төрлийн 86520 ширхэг нийт 106580 ширхэг тарьц суулгацыг бэлтгэн үржүүллээ.

4.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй хэрэгжүүлж, цөлжилтийг бууруулах чиглэлээр бусад улс орны туршлагыг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллаж байна.

7.Нэгдсэн Үндэсний байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төсөлтэй хамтран аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 172.0 сая төгрөг, төслийн 102,2 сая төгрөг нийт 174.2 сая төгрөгийн санхүүжилтээр байгалийн ойн сэргэн ургалтыг дэмжин Шинэжинст сумын нутаг дэвсгэрт 1000 га талбайд заг бүхий талбайг хашиж хамгаалах судалгааны ажлыг ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтэдтэй хамтран гүйцэтгэж, 4 байршилд 300 га талбайд заган ойг хашиж хамгаалсан.

8.Улсын төсвийн санхүүжилтээр ойн хомсдол доройтлыг бууруулах зорилгоор ойн сан бүхий 26000 га талбайд ойн хөнөөлт шавжийн судалгааг хийж гүйцэтгэхэд 7000 га талбайд ойн хөнөөлт шавжийн тархалт голомттой байгааг тогтоож, микробиологийн аргаар үүргийн шүршигч багаж ашиглан тэмцлийн ажлыг зохион байгуулав.

11.2.Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой “Хог хаягдал” төсөл, арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийг 90% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэв.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор батлагдсан “Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 3 дахь жилдээ

хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөр нь 4 бүлэг 26 зорилтоос бүрдэх бөгөөд 2022 онд 78.5 хувь, 2023 онд 79.6 хувь, 2024 онд 90.1 хувьтай хэрэгжүүлж ажилласан.

11.2.1.Аймгийн 20 сумд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн төсөв, хандив дэмжлэгийн хүрээнд хог хаягдлын төвлөрсөн цэгийг сайжруулан тохижуулж, хур хогийг түрж булшлан талбайг чөлөөлөх, хашаалах, даланжуулах, үерийн суваг татах, ковшжуулах, камержуулах зэрэг цэгцлэх ажлууд бүрэн хийгдсэн үр дүнтэй байна.

11.2.2.Сумдын Засаг даргын Тамгын газраас тэмдэглэлт өдөр, баяр наадам зэргийг тохиолдуулан бүх нийтийн цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж хэвшсэн төдийгүй аймгийн хэмжээнд бүх нийтийн цэвэрлэгээг сар бүр зохион байгуулж тогтмолжуулсан.

Тайлант онд бүх нийтийн цэвэрлэгээнд 396 аж ахуй нэгж, албан байгууллагын 10841 иргэн оролцож 8844.6 га талбайгаас 156.459 тн хог хаягдлыг цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн байна.

Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор аймгийн хэмжээнд 20 сумын 245229 мал, амьтан зүй бусаар хорогдсон. /Тэмээ-262, Адуу- 10259, Үхэр- 32111, Хонь- 73522, Ямаа- 129075/ Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх малын сэг, зэм устгалыг 20 сумын 104 багийн түвшинд 53 устгалын цэгт устгал, ариутгалын ажлыг хийж, 96.0%-тай гүйцэтгэсэн.

11.2.3.Баянхонгор, Галуут, Баянлиг, Баянговь, Шинэжинст, Өлзийт, Заг, Хүрээмарал, Баян-Өндөр, Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан зэрэг нийт 12 сумдад дахивар, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, тоног төхөөрөмжтэй болж, аймгийн хэмжээнд нийт 818.2 тн буюу нийт хог хаягдлын 1.35 хувийг эдийн засгийн эргэлтэд оруулсан байна.

11.2.4.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тогтолцоог аймгийн хэмжээнд нэвтрүүлж ажиллаж байгаа ба эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломжтой 543 ширхэг хогийн савыг сүүлийн 3 жилд шинээр байршуулсан.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 200.0 сая төгрөгийн санхүүжилтээр Жаргалант, Бөмбөгөр, Баянбулаг, Бууцагаан суманд өөрөө буулгагч хог тээврийн автомашин, Баянхонгор суманд өөрөө шахагч хог тээврийн автомашин худалдан авч, үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нь сайшаалтай.

11.3.Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой “Цахим” төсөл, арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийг 90 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэв.

Баянхонгор аймаг нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн тоон бичиг үсгийн чадавхыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг 2024 онд цахимжуулахад анхаарч ажилласан ба хэрэгжилтийг 90 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Баянхонгор аймаг дахь төрийн цахим үйлчилгээний хэлтэс нь төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, шат дамжлагагүй түргэн шуурхай хүргэх зорилгоор аймгийн төвдөө 3, хөдөөгийн 8 сумд ХУРДАН цэгээ байгуулан үйл ажиллагаагаа олон нийтэд хүргэн ажиллалаа. Тус цэгүүдээрээ дамжуулан төрийн үйлчилгээг иргэдэд операторын горимоор хүргэж, 2024 онд 30 мянга гаруй иргэнд 37452 төрийн үйлчилгээг хүргэлээ. Нийт 43 байгууллагын 478 төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар үзүүлж байна.

"Иргэдийн санал гомдол илгээх систем" (<https://irgen.bayanhongor.gov.mn/>)-ийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж, тус системээр дамжуулан төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авах, иргэдээс өргөдөл, санал гомдол хүлээж авах, шийдвэрлэх явцыг тухайн мэдээлэл оруулсан иргэний гар утсанд шууд мэдээлэх зэрэг цахим технологийг нэвтрүүлснээр иргэд төрийн байгууллагын үйл ажиллагаанд шууд хяналт хийх боломжтой болсон. Мөн тус системд аймгийн бүх төрийн болон орон нутгийн байгууллагын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтнүүдийг бүртгэн баталгаажуулж, тухайн байгууллагад ирсэн өргөдөл санал гомдлыг шуурхай шийдвэрлэх, шийдвэрлэгдэх явцыг цаг тухай бүрд мессежээр тухайн иргэнд мэдээлэх боломж үүссэн.

Цахим гарын үсгийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал батлах тухай зэрэг хууль журмуудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Баянхонгор аймгийн төсвийн байгууллагын 100 хувь нь erp.e-mongolia.mn байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP систем ашиглаж байна.

Онцгой чиг үүргийн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Able систем, Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар, Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Баянхонгор аймгийн онцгой байдлын газрууд EDoc систем, Баянхонгор аймгийн прокурорын газар ErpProsecutor систем тус тус ашиглаж байна.

И-Монгол академиас хөгжүүлэлт хийгдэж буй erp.e-mongolia.mn Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд төсвийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагыг бүрэн шилжүүлж 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 210 байгууллагын 4346 төрийн албан хаагч бүртгэгдэж албан бичиг, дотоод удирдлагын хяналт, мэдээлэл солилцооны нэгдсэн системээр дамжуулан үйл ажиллагаагаа явуулсан байна.

Эдгээр албан бичиг солилцооны дундын системүүд болон Монгол Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа 13 төрлийн систем хооронд цахим хэлбэрээр албан бичиг илгээх, хүлээн авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс хамтран нэгдсэн зохион байгуулалттайгаар Docx.gov.mn албан бичиг солилцооны дундын системд холбох ажлыг бүрэн хийв.

2024 оны жилийн эцсийн байдлаар 142 байгууллага Албан бичиг солилцооны дундын систем (Docx.gov.mn) системд холбогдон 100 хувь ашиглаж байна.

Цахим хөгжил, харилцаа, холбооны яамнаас зохион байгуулсан “ЦАХИМД ХЭВШЬЕ-D1” Орон нутагт салбар байгууллагын мэдээллийн технологи хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах, нэгдсэн арга зүйгээр хангах, сургалт арга хэмжээнд төрийн болон хувийн хэвслүүдийн мэдээллийн технологи хариуцсан 40 гаруй албан хаагчийг хамруулсан.

Орон нутгийн хэмжээнд бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх тоон бичиг үсгийн чадавхыг нэмэгдүүлэх чиг үүргийн хүрээнд аймгийн 19 сумын төрийн байгууллагын 2700 гаруй албан хаагч, ахлах ангийн багш, сурагчдад сургалт зохион байгуулсан.

Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-тай хамтран “Цахимд зөв байя” уриатай сарын аяныг зохион байгуулж төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд, сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагч, Баянхонгор сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчид зэрэг 970 гаруй иргэнийг хамруулан амжилттай зохион байгуулж тайлан мэдээг хүргүүлэн ажилласан.

И-Монгол системд шинээр нэвтрүүлэх үйлчилгээг судлах, төрийн үйлчилгээний хэрэглээний тандалтын судалгааг хийж, төрийн болон орон нутгийн өмчит 52 байгууллагын 128 үйлчилгээнд дахин инженерчлэл хөгжүүлэлт хийгдсэн.

Шинээр 4 байгууллагын 4 үйлчилгээг цахим үйлчилгээний жагсаалтад бүртгэв.

Аймгийн хэмжээнд И-Монгол системд 39748 иргэн бүртгэлтэй байна.

Цахимжсан үйлчилгээнд дахин загварчлал хийх, шаардлагагүй шат дамжлага, үйлчилгээний шийдвэрлэх хугацааг богиносгох, үйлчилгээний хүсэлтийг шийдвэрлэх, эрхийн тохиргоог хийх, хэрэглэгчид цахим ур чадвар олгох сургалт, мэдээллийн ажлыг шат дараатайгаар зохион байгуулан ажилласан.

Арван хоёр. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тойм:

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 44 шалгуур үзүүлэлтийн дундаж 90.6 хувьтай байна. Тус шалгуур үзүүлэлтээс харахад аймгийн гэмт хэргийн тоо өссөн, иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин буурсан, эхийн эндэгдэл болон нялхсын эндэгдлийн түвшин тус тус өссөн байна.

Арван гурав: Зөвлөмжийн хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2024 оны 01/620, дугаар албан бичгээр ирүүлсэн аймгийн 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, удаашралтай заалт арга хэмжээний хэрэгжилтийг дунджаар 90 хүртэл хувьд хүргэн эрчимжүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилтийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 2/1415 тоот албан бичгээр monitoring.ags@gmail.com хаягаар хүргүүлсэн болно.

Хоёрдугаар бүлэг: Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон бусад ажил

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг сумын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн өмчийн байгууллагуудын 2023, 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажилласан ба албан хаагчдыг чадавхжуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний ил тод байдлыг хангах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1.Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний <http://bayankhongor.igovernment.mn> цахим системээр 16 төрлийн тайланг 20 сум, 24 агентлаг, 11 төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын 8 нэгжээс хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж, давхардсан тоогоор 783 байгууллага, нэгжид 6010 бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийг хуваарилж, 54298 заалтын хэрэгжилтэд 2-11 удаагийн давтамжтай хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажиллалаа. Үүнд:

Д/д	Тайлагнасан баримт	Тайлагнасан	Хяналтад байгаа	Үнэлгээ	ХШҮ
-----	--------------------	-------------	-----------------	---------	-----

	бичгийн нэр	байгууллага, АЗДТГ-ын нэгжийн тоо	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	хийсэн давамж	хийсэн заалтын тоо
1	2	3	4	5	6	7
1	Монгол Улсын Засгийн газрын 2020- 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан	12	1	35	5	175
2	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлийн тайлан	35	1	344	1	344
3	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан	59	1	1137	2	2274
4	Аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан	51	1	1065	2	2130
5	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан	20	20	2070	2	4140
6	Дэд хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан	58	162	860	2	1720
7	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	62	1144	1768	11	8584
8	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт	63	638	651	2	651
9	Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт	63	3936	10752	4	10752
10	Засгийн газрын гишүүн-Засаг даргатай байгуулсан гэрээ, (Засгийн газрын зарим чиг үүргийн орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө)-ий хэрэгжилт	42	19	1626	2	3252
11	Аймгийн Засаг дарга- Сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт	40	20	2765	2	5530
12	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний	55	55	2835	2	5670

	хэрэгжилт					
13	Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	54	1	378	2	756
14	Ил тод байдлын шалгуурын тайлан	54	1	2484	2	4968
15	Зөвлөмжийн хэрэгжилт	60	8	815	2	1630
16	Байгууллагын тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийн тайлан	35	1	161	2	322
17	Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн тайлан	20	1	35	2	1400
	Дүн	783	6010	29781	47	54298

*Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд "Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний систем байдаг хэдий ч 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан шинэ аргачлалаар боловсруулсан тул цахим сангаар 2024 онд тайлан авах боломжгүй нөхцөл үүссэн.

Дээрх цахим тайлангаас гадна харьяа байгууллага, сумдаас ирүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан "Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын 15 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллага, нэгжийн тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт", Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт зэрэг тайланг цаасаар хүлээн авч үнэлж ажиллалаа.

2.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, сумдын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн өмчийн болон босоо удирдлагатай төрийн өмчийн нийт 55 байгууллагад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулж, бодлогын зөвлөгөө, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах зорилгоор зөвлөн туслах үйлчилгээг 2024 оны 2 дугаар сар, 2025 оны 1 дүгээр сард тус тус зохион байгуулж, цахим тайлангийн бодит гүйцэтгэлтэй танилцаж, зөвлөгөө өгсөн.

3.Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээс гарсан нэгдсэн дүгнэлт зөвлөмжийг аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, “Бодлогын баримт бичгийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн батлуулах тухай” аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар албан даалгаврыг гарган хэрэгжилтийг хангуулан ажилласан.

4.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт Байгууллагуудын 2024 оны эхний хагас жил, жилийн эцсийн бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмж, тайланг байгууллага тус бүрт 2 удаа хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажилласан.

5.Бодлогын баримт бичгийн төлөвлөлтийг сайжруулах зорилгоор “Хөгжлийн бодлого төлөвлөлт, гүйцэтгэл сургалтыг 2024 оны 10, 11 дүгээр сард зохион байгуулж 200 гаруй төрийн албан хаагчдыг хамруулсан. Сургалтын үр дүнд аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнд суурилсан төлөвлөлтийн аргачлалаар 4 түвшний үр дүнг тодорхойлон боловсруулсан. Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн тайлагналтыг сайжруулах зорилгоор цахим болон танхим хосолсон сургалтыг аймгийн хэмжээнд 2 удаа зохион байгуулсны үр дүнд 2024 оны жилийн эцсийн нутаг дэвсгэрийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн тайлагналт 2023 оны жилийн эцэстэй харьцуулахад 17 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



“Хөгжлийн бодлого-Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сургалт

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн судлаач, ахлах референт Т.Оюунаар ахлуулсан ажлын хэсэг Баянхонгор аймагт 2024 оны 11 дүгээр сарын 07-нд ажиллаж, Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар, төрийн захиргааны байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит

аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд, бодлого төлөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалт, дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч албан 67 хаагчдыг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулав. Үүнд: Үнэлгээ мониторингийн эрх зүйн орчин, тогтолцоо, шинэчлэлийн бодлогын талаар “Мониторинг хийх нийтлэг журам”, “Үнэлгээ хийх нийтлэг журам”, “Төрийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлагыг дүгнэх журам” зэрэг гурван журмын төслийн танилцуулгыг хийж санал авлаа.



Дүгнэлт:

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд сум, харьяа байгууллагын үйл ажиллагаанд 2 удаа зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 2 удаагийн сургалт зохион байгуулж, 20 сум, 24 агентлаг, 11 төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын 8 нэгжийн 19 төрлийн 6010 тайлангийн 54298 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөмжөөр хангаж ажилласан байна.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг цахимаар болон бусад хэлбэрээр хийсний үр дүнд нутгийн захиргааны байгууллагуудын ил тод байдал нэмэгдэж, төрийн албан хаагчдын үүрэг хариуцлага, байгууллага хоорондын уялдаа холбоо сайжирч, цаг хугацааны болон төсвийн хэмнэлт бий болсон байна.

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн дуусгавар болсон, бүрэн хэрэгжсэн, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон заалтыг холбогдох дээд шатны байгууллага хяналтаас хасдаггүй, сар бүр тайлан авдаг хэдий ч үнэлдэггүй нь бүх шатанд хэт ачаалал үүсгэсэн, үр дүнгүй ажил болжээ.

Бодлогын баримт бичгийг боловсруулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх зүйн орчны уялдаагүй байдал нь төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэлийн тайлагналт, үнэлгээ хийхэд хүндрэл учруулсан байна.

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээ хийх журам, аргачлалын зөрүүтэй байдал нь тус тайлангийн үнэлгээг Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем (new.unelgee.gov.mn), Нээлттэй мэдээллийн цахим хуудас (shilen.gov.mn) гэсэн 2 сувгаар хүлээн авч, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам” зэрэг 2 журмаар, хоёр дахин үнэлгээ хийх нөхцөлийг бүрдүүлж, ажлын ачаалал үүсгэж байгаагийн зэрэгцээ үнэлгээний зөрүүтэй байдлыг бий болгосон байна.

Санал:

Баянхонгор аймгийн 2024 оны бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг үндэслэн дараах асуудлыг анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт хийх эрх зүйн орчны (төлөвлөлт, тайлагналт, цаглавар хоорондын) уялдааг сайжруулах, үүнд: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн Сайдын 2023 оны А/26 дугаар тушаал

2.Хөгжлийн бодлого, төлөвлөлт хийхэд баримтлах салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчийн, хөтөлбөрийн үр дүн болон шалгуур үзүүлэлтийн мэдээллийн сан, ангилал, заавартай болох

3.Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд үр дүнд суурилсан төлөвлөлтийн аргачлалаар боловсруулсан бодлогын баримт бичгийн гүйцэтгэлийг тайлагнах системийн хөгжүүлэлт хийх

4.Байгууллагын ил тод байдлын шалгуурыг нээлттэй байршуулсан тайланг холбох 1 систем, 1 үнэлгээний аргачлалтай болох

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМБЫН ГАЗРЫН
ДАРГА

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН САЛБАРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.МӨНХСАЙХАН

Д.ЭНХЖАРГАЛ

Б.БУЛГАМАА

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	96.13	0.5	4.68
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	89.41		
	3. Аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	87.2		
	4. Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	91.14		
	5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	90.6		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	96.8	0.15	
	2. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	96.2		
	3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	100		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдал	100	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлт	-		
	3. Шударга байдлын түвшин	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-		
Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт	90	0.15	
Ерөнхий үнэлгээ:		93.6	0.94	

ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

Д.ЭНХЖАРГАЛ

ДҮНГ НЭГТГЭСЭН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.БУЛГАМАА